

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага.....	13
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	13
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.6 Өр төлбөр.....	15
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.7 Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	18
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	19
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕГ	Татварын ерөнхий газар
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ЗАЯАБАЛ ТАНАА

2021.03.25 № 01/986
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Татварын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Татварын ерөнхий газар 2020 онд үндсэн чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт зорилтын 3 арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын 10 арга хэмжээ, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 4 зорилтын 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн биелэлт 97 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,787,261.2	4,113,161.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,949.2	882,214.4
33	АВЛАГА	230,151.6	933,543.6
34	УРЬДЧИЛГАА	847,669.0	10,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,347,192.8	2,287,403.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,324,298.6	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,730,159.1	45,175,692.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,730,159.1	45,175,692.5
39200	Биет хөрөнгө	19,781,238.9	41,832,877.5
39300	Биет бус хөрөнгө	2,948,920.2	3,342,814.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,517,420.3	49,288,853.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,396.8	30,579.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,396.8	30,579.3
41300	Өглөг	20,396.8	11,624.0
41400	Урьдчилж орсон орлого	-	18,955.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,497,023.4	49,258,274.4
51	Засгийн газрын хувь оролцоо	26,497,023.4	49,258,274.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,015,564.2	20,015,564.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,345,945.6	25,085,966.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,135,513.6	4,156,743.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,517,420.3	49,288,853.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42,697,331.2	73,483,346.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,723,808.9	28,073,062.6
120	Нийтлэг татварын бус орлого	5,723,808.9	28,073,062.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,973,522.3	45,410,284.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	38,976,770.1	49,126,210.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,976,770.1	49,126,210.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,531,400.6	45,073,045.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,367,031.3	26,390,208.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,058,958.1	3,372,544.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,404,156.9	1,511,154.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,246,956.8	1,883,308.8
2105	Нормативт зардал	75,635.1	42,509.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	492,316.1	295,380.5
2107	Томилолт, зочны зардал	265,028.1	166,832.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,646,992.6	5,636,548.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,974,325.6	5,774,557.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,445,369.5	4,053,165.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,720,561.1	24,357,136.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,768.3	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,015,416.7	259,253.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,715,912.8	24,097,882.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	183,812,439.3	337,066,697.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,138,769.8	6,814,066.2
120	Нийтлэг татварын бус орлого	4,138,769.8	6,814,066.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	179,673,669.5	330,252,630.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,056,782.2	330,401,270.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,056,782.2	330,401,270.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,102,749.1	40,167,257.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,267,700.3	26,364,433.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,134,788.8	3,349,773.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,402,914.6	1,511,493.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,002,030.6	1,484,092.8
2105	Нормативт зардал	960,247.6	295,526.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	603,256.5	333,928.4
2107	Томилолт, зочны зардал	275,529.8	154,011.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,504,685.0	5,989,222.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	951,596.0	684,775.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,954,033.1	290,234,013.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	755,657.0	6,665,426.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,583,552.2	5,821,161.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,583,552.2	5,821,161.2
2200	Дотоод эх үүсвэрээр	1,583,552.2	5,821,161.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,583,552.2	-5,821,161.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-827,895.2	844,265.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	865,844.3	37,949.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,949.20	882,214.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,058,768.0	-	24,058,768.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-295,053.1	-	-295,053.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,763,715.0	-	23,763,715.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	17,395.7	-	17,395.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	2,715,912.8	-	2,715,912.8
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,497,023.4	-	26,497,023.4
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,338,246.6	-	-1,338,246.6
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,158,776.8	-	25,158,776.8
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,614.7	-	1,614.7
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
16	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
17	Зарласан ногдол ашиг	-	-	-
18	Тайлант үеийн үр дүн	24,097,882.9	-	24,097,882.9
19	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	49,258,274.4	-	49,258,274.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,818,900,600.00	46,474,718,418.62	3,344,182,181.38	93.3
УРСГАЛ ЗАРДАЛ	44,658,500,600.00	41,752,498,507.62	2,906,002,092.38	93.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,126,636,200.00	40,228,143,729.62	2,898,492,470.38	93.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,432,677,800.00	26,023,388,785.84	2,409,289,014.16	91.5
Үндсэн цалин	18,078,886,100.00	16,863,845,708.18	1,215,040,391.82	93.3
Нэмэгдэл	5,520,106,400.00	5,055,098,525.36	465,007,874.64	91.6
Унаа хоолны хөнгөлөлт	1,760,035,000.00	1,580,653,448.39	179,381,551.61	89.8
Урамшуулал	3,073,650,300.00	2,523,791,103.91	549,859,196.09	82.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,686,795,500.00	3,310,730,656.92	376,064,843.08	89.8
Тэтгэврийн даатгал	2,544,884,300.00	2,327,104,943.91	217,779,356.09	91.4
Тэтгэмжийн даатгал	285,477,900.00	248,870,980.54	36,606,919.46	87.2
ҮОМШӨ-ний даатгал	228,382,200.00	194,725,680.06	33,656,519.94	85.3
Ажилгүйдлийн даатгал	57,095,600.00	50,387,093.58	6,708,506.42	88.3
Эрүүл мэндийн даатгал	570,955,500.00	489,641,958.83	81,313,541.17	85.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,555,344,500.00	1,487,386,757.33	67,957,742.67	95.6
Гэрэл, цахилгаан	230,767,500.00	196,092,587.38	34,674,912.62	85.0
Түлш, халаалт	538,708,100.00	511,521,195.76	27,186,904.24	95.0
Цэвэр, бохир ус	71,006,100.00	64,965,028.19	6,041,071.81	91.5
Байрны түрээс	714,862,800.00	714,807,946.00	54,854.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	1,344,882,700.00	1,336,144,032.18	8,738,667.82	99.4
Бичиг хэрэг	311,090,000.00	310,410,667.50	679,332.50	99.8
Тээвэр, шатахуун	169,342,500.00	169,251,539.30	90,960.70	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	339,647,800.00	337,358,931.38	2,288,868.62	99.3
Ном, хэвлэл	27,636,500.00	27,384,640.00	251,860.00	99.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,434,900.00	26,764,200.00	2,670,700.00	90.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	467,731,000.00	464,974,054.00	2,756,946.00	99.4
Нормативт зардал	295,236,100.00	295,226,400.00	9,700.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	1,990,380.00	9,620.00	99.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,236,100.00	293,236,020.00	80.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	705,505,100.00	700,734,581.00	4,770,519.00	99.3
Багаж, техник, хэрэгсэл	431,869,600.00	431,545,600.00	324,000.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,539,300.00	7,432,100.00	107,200.00	98.6
Урсгал засвар	266,096,200.00	261,756,881.00	4,339,319.00	98.4
Томилолт, зочны зардал	165,946,600.00	154,011,462.00	11,935,138.00	92.8
Дотоод албан томилолт	129,589,100.00	120,420,400.00	9,168,700.00	92.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	36,357,500.00	33,591,062.00	2,766,438.00	92.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,092,450,400.00	6,075,053,347.95	17,397,052.05	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,510,518,400.00	2,504,920,022.96	5,598,377.04	99.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,595,400.00	9,765,000.00	830,400.00	92.2
Даатгалын үйлчилгээ	29,444,100.00	28,526,150.51	917,949.49	96.9
Тээврийн хэрэгслийн татвар	5,558,000.00	4,991,254.00	566,746.00	89.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,943,200.00	1,246,178.00	697,022.00	64.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	514,614,700.00	506,247,437.46	8,367,262.54	98.4
Газрын төлбөр	5,776,500.00	5,357,226.00	419,274.00	92.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,014,000,100.00	3,014,000,079.02	20.98	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	847,797,500.00	845,467,706.40	2,329,793.60	99.7

Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	596,337,400.00	596,154,307.00	183,093.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	251,460,100.00	249,313,399.40	2,146,700.60	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,531,864,400.00	1,524,354,778.00	7,509,622.00	99.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	89,583,900.00	82,788,300.00	6,795,600.00	92.4
Засгийн газрын дотоод шилжүүлэг	89,583,900.00	82,788,300.00	6,795,600.00	92.4
Бусад урсгал шилжүүлэг	1,442,280,500.00	1,441,566,478.00	714,022.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	213,230,800.00	213,062,963.00	167,837.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,084,739,200.00	1,084,736,881.00	2,319.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	144,310,500.00	143,766,634.00	543,866.00	99.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,160,400,000.00	4,722,219,911.00	438,180,089.00	91.5
Барилга байгууламж	3,460,400,000.00	3,573,700,775.00	-113,300,775.00	103.3
Их засвар	700,000,000.00	555,421,936.00	144,578,064.00	79.3
Тоног төхөөрөмж	1,000,000,000.00	593,097,200.00	406,902,800.00	59.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,818,900,600.00	46,474,718,418.62	3,344,182,181.38	93.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,803,465,500.00	42,911,450,137.62	2,892,015,362.38	93.7
Улсын төсвөөс санхүүжих	45,803,465,500.00	42,911,450,137.62	2,892,015,362.38	93.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,015,435,100.00	3,563,268,281.00	452,166,819.00	88.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,736,435,100.00	3,552,184,800.00	184,250,300.00	95.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	279,000,000.00	11,083,481.00	267,916,519.00	4.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,678.00	-1,678.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,678.00	-1,678.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,768.00	3,704.00	64.00	98.3
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,884.00	1,852.00	32.00	98.3
Удирдах ажилтан	38	38	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,713.00	1,681.00	32.00	98.1
Үйлчлэх ажилтан	133	133	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,884.00	1,852.00	32.00	98.3
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,562.00	1,530.00	32.00	98.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	322	322	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,341,224,885.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,336,410,585.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,393,421.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,044,615.18
210101	Үндсэн цалин	323,089,615.18
210104	Урамшуулал	17,955,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,042,807.96
210201	Тэтгэврийн даатгал	39,042,807.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,106,276.00
210304	Байрны түрээс	24,106,276.00
2104	Хангамж, бараа материалын зардал	182,076,219.29
210401	Бичиг хэрэг	93,352,711.20
210402	Тээвэр, шатахуун	28,235,216.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,721,702.09
210404	Ном, хэвлэл	9,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	996,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,770,590.00
2105	Нормативт зардал	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	96,876,488.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,350,076.00
210602	Тавилга	22,485,812.00
210604	Урсгал засвар	18,040,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,409,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,456,158.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,612.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	836,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,537,245.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,156,107.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,381,138.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	326,017,164.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	957,600.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	957,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,185,090.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,845,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,340,090.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	217,874,474.05
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,116,909.87
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	215,757,564.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,814,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,814,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,814,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,341,224,885.48
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,341,224,885.48
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	763,287,459.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	576,042,426.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,895,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	150
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	150

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Заяабал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шалгагдагч этгээдийн урсгал зардлын төсвөөс хөрөнгө бэлтгэхгүй байх, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй тооцох, санхүүгийн тайланг хуулийн дагуу иж бүрэн тайлагнаж, хүргүүлэх, гэрээт ажлын гүйцэтгэлийн холбогдох нотлох баримтын бүрдлийг хангаж бүртгэл тайланд тусгах, үр ашиггүй зардал гаргахгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам гүйцэтгэв.

Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/560 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, гэж тодорхойлсон байна. Татварын ерөнхий газрын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Татварын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Татварын ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Татварын ерөнхий газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь 2020 онд 7 зорилтын 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн гүйцэтгэсэн байна. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд харьяа 1 газар, 3 хэлтсийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Татварын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, зөвлөмж өгч ажилласан байна.

Татварын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 583.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,385.5 сая төгрөгийн 1.5 хувиар тооцож, 740.8 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тогтоосныг дахин тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 37.9 сая, эцсийн үлдэгдэл 882.2 сая төгрөг болж, өмнөх оноос 844.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	37.9	882.2	844.3
Дүн	37.9	882.2	844.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 835.4 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 46.8 сая төгрөг ахмадын сангийн дансанд, 1.7 мянган төгрөг мөнгөн кассын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Кассын тайлан бэлтгээгүй, бэлнээр зарцуулсан 4.2 сая, И-баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 64.4 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- И-баримтгүй болон зөрүүтэй дүнтэй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан. /Хан-Уул 0.9 сая, Чингэлтэй 3.7 сая, Баянгол 22.5 сая, Налайх 9.6 сая, Багануур 0.8 сая, Сүхбаатар дүүрэг 10.8 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Баянгол 15.7 сая, Багануур 0.4 сая төгрөг/;
- Ховд аймгийн Татварын хэлтэс нь бэлнээр авч зарцуулсан 4.2 сая төгрөгийг кассын тайланд бүртгээгүй, тооллого хийгээгүй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 230.2 сая, эцсийн үлдэгдэл 933.5 сая төгрөг болж, өмнөх оноос 703.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.3	0.3
Татаас, санхүүжилтийн авлага	206.5	198.5	-8.0
Байгууллагаас авах авлага	20.5	730.8	710.3
Хувь хүмүүсээс авах авлага	3.1	3.9	0.8
Дүн	230.1	933.5	703.4

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь Татварын ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн 198.5 сая, байгууллагаас авах авлага 687.8 сая төгрөгөөр нэмэгдсэн зэргээс голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 18.8 сая төгрөгийн дараах авлага байна. Тухайлбал:

- Сангийн яамнаас авах 2013-2014 онд үүссэн 2.3 сая төгрөгийн авлага. /Хан-Уул дүүрэг 1.1 сая, Увс 0.6 сая, Хэнтий 0.6 сая, бусад 5 аймаг 31.1 мянган төгрөг/;
- Дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 11.9 сая төгрөгийн авлага. /Нийслэл Сэргээн босголт банк 9.8 сая, Сонгинохайрхан Сэргээн болголт банк 0.7 сая, Хөвсгөл аймаг Сэргээн босголт банк 1.4 сая төгрөг/;
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай холбоотой 2.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /Нийслэл 0.5 сая, Багахангай 0.2 сая, Баянзүрх 2.2 сая төгрөг/

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 847.7 сая, эцсийн үлдэгдэл 10.0 сая төгрөг болж, өмнөх оноос 837.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	847.7	10.0	-837.7
Дүн	847.7	10.0	837.7

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 837.7 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд улсын байцаагчийн ажлын хувцас үйлдвэрлэн нийлүүлэх гэрээний дагуу 830.3 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад урьдчилан шилжүүлсэн боловч гэрээт ажил хийгдээгүй тул гэрээг цуцлан, төлбөрөө буцаан авснаас шалтгаалжээ.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,347.1 сая, эцсийн үлдэгдэл 2,287.3 сая төгрөг болж, өмнөх оноос 940.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0.7	-	-0.7
Эм боох	-	1.6	1.6
Бэлэн бүтээгдэхүүн	65.7	55.3	-10.4
Бичиг хэргийн материал	248.6	484.8	236.2
Аж ахуйн материал	471.6	668.5	196.9
Сэлбэг хэрэгсэл	12.3	29.7	17.4
Түлш, шатах тослох материал	17.7	22.5	4.8
Барилгын засварын материал	31.1	72.0	40.9
Хүнсний материал	1.2	4.4	3.2
Бусад хангамжийн материал	493.4	943.1	449.7
Мал амьтад	4.8	5.4	0.6
Дүн	1,347.1	2,287.3	940.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,324.3	-	-1,324.3
Дүн	1,324.3	-	-1,324.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд бичиг хэргийн материал 236.2 сая, аж ахуйн материал 196.9 сая, бусад хангамжийн материал 449.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант оны эцэст ТЕГ нь 33.4 сая төгрөгийн бичгийн цаас, 24.7 сая төгрөгийн принтерийн хор, бага насны хүүхдүүдэд татварын боловсрол олгох зорилгоор хийлгэсэн 16.4 сая төгрөгийн пазле карт буюу буддаг ном, 103.8 сая төгрөгийн Татварын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, Санхүүгийн олон улсын эмхэтгэл, Давхар татварын олон улсын гэрээний эмхэтгэлийн ном зэргийг худалдан авч бэлтгэснээс бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Мөн бусад хангамжийн материалын өсөлт нь Татварын улсын байцаагчийн зөвлөх тэмдэг, итгэмжит зөвлөх, хүндэт тэмдэг, жуух бичиг нийт 23.7 сая, гадаадын зээл тусламжаар бэлтгэсэн 74.2 сая төгрөгийн хангамжийн материалаас голлон нөлөөлжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болох ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 1,324.3 сая төгрөгийн Сэлэнгэ аймгийн татварын хэлтсийн барилгыг өмнөх онд Татварын ерөнхий газрын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэснийг Сангийн сайдын 38 дугаар тушаалаар бүх эрхийг орон нутагт шилжүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр залруулсан байна.

Аудитын илрүүлэлт: Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн, бараа материалын үлдэгдэл, тооллогын дүн, тодруулга тайлангаас зөрүүтэй, бараа материалыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан зэрэг нийт 34.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд: /Дархан-Уул 25.3 сая, Чингэлтэй 4.3 сая, Багануур 2.9 сая, Сүхбаатар дүүрэг 1.9 сая төгрөг/

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 34,392.3 сая, эцсийн үлдэгдэл 59,819.9 сая төгрөг болж, өмнөх оноос 25,427.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	28,995.2	51,082.7	22,087.5
Барилга, байгууламж, орон сууц	15,690.2	18,000.8	2,310.6
Авто-тээврийн хэрэгсэл	3,117.4	3,641.3	523.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,002.0	23,678.8	16,676.8

Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тавилга, аж ахуйн эд хогшил	2,824.5	3,021.6	197.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.1	0.1	-
Бусад үндсэн хөрөнгө	357.6	359.4	1.8
Дуусаагүй барилга байгууламж	-	2,375.4	2,375.4
Ном	3.4	5.3	1.9
Биет бус хөрөнгө	5,397.1	8,737.2	3,340.1
Программ хангамж	3,927.8	4,640.5	712.7
Бусад биет бус хөрөнгө	1,469.3	4,096.7	2,627.4
Дүн	34,392.3	59,819.9	25,427.6

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 5,354.7 сая, урсгал зардлын төсвөөс бэлтгэсэн 483.4 сая, хандиваар 623.6 сая, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 21,167.0 сая, дээд шатны болон бусад байгууллагаас балансаас балансад шилжүүлэн авсан 500.2 сая, үндсэн үйл ажиллагааны болон давсан орлогоос бэлтгэсэн 42.7 сая, бусад эх үүсвэрээс 162.2 сая, нийт 28,333.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 899.4 сая, акталсан 1,982.1 сая, бусад 24.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж данс 2,375.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хөвсгөл, Увс, Баянхонгор аймгуудын татварын хэлтсүүдийн барилгын ажил он дамжин хэрэгжсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт: Их засварын зардлыг капиталжуулаагүй, жилийн эцсийн тооллогыг хангалтгүй зохион байгуулсан, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж шийдвэрлээгүй зэрэг нийт 756.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Их засварын зардлыг капиталжуулж бүртгээгүй. /Төв 113.3 сая, Завхан 51.4 сая төгрөг/
- Хөрөнгийн тооллого хийгээгүй, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж шийдвэрлээгүй. /Төв 575.6 сая, Сонгино хайрхан 16.0 сая төгрөг/

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20.4 сая, эцсийн үлдэгдэл 30.6 сая төгрөг болж, өмнөх оноос 10.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	1.6	4.2	2.6
Байгууллагад төлөх өглөг	17.2	6.1	-11.1
Хувь хүмүүст төлөх өглөг	1.6	-	-1.6
Татварын өглөг	-	0.8	0.8
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	-	0.5	0.5
Бусад урьдчилж орсон орлого	-	19.0	19.0
Дүн	20.4	30.6	10.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 5.2 сая төгрөгийн барьцаа, 19.0 сая төгрөгийн орлогын албан татварын тэмдэгтийн төлбөр, 2.2 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 4.2 сая төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өр байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 26,497.0 сая, эцсийн үлдэгдэл 49,258.3 сая төгрөг болж, өмнөх оноос 22,761.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	20,015.6	20,015.6	-
Хуримтлагдсан үр дүн	2,345.9	25,086.0	22,740.1

Өмнөх үеийн үр дүн	-370.0	988.1	1,358.1
Тайлант үеийн үр дүн	2,715.9	24,097.9	21,382.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,135.5	4,156.7	21.2
Дүн	26,497.0	49,258.3	22,761.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 24,097.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд тайлант онд хөрөнгө акталж устгаснаас үүссэн дахин үнэлгээний зөрүү 1.5 сая, акталсан хөрөнгийн өсөлт бууралт 7.2 сая, балансаас балансад шилжүүлэн авсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1.6 сая, шүүхийн шийдвэрээр авлага хаасан 1.7 сая, аудитын зөвлөмжөөр бүртгэсэн 5.1 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болох ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 1,324.3 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэн Сэлэнгэ аймгийн барилга зэргийг залруулан бүртгэж, тайлагнасан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 79,806.7 сая төгрөгөөр, урсгал төсвийн зардалд 51,769.2 сая, хөрөнгө оруулалтын зардалд 28,037.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн дээд шатны төсөв захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 29,987.8 сая төгрөгөөр бууруулж, 49,818.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 49,818.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 44,658.5 сая төгрөгийг урсгал зардалд, 5,160.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 45,803.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,015.4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 45,363.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 440.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Тайлант онд 4,015.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 3,563.3 сая төгрөгийг төвлөрүүлж 88.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт № 8. Үйл ажиллагааны орлого

			/сая төгрөг/	
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,736.4	3,552.2	184.2	95.1
Туслах үйл ажиллагааны орлого	279.0	11.1	267.9	0.1
Нийт дүн	4,015.4	3,563.3	452.1	88.7

Ковид цар тахлын үед согтууруулах ундаа зарахыг хориглосонтой холбогдуулан онцгой албан татварын тэмдэгтийн захиалга буурснаас үндсэн үйл ажиллагааны орлого 184.2 сая, татварын шинэчилсэн хуулиар АТБӨЯХ-ийн албан татварын гэрчилгээ, иргэний орлогын цэнхэр дэвтэр, НӨАТ-ын гэрчилгээ хүчингүй болж, цахим хэлбэрт шилжсэнээс туслах үйл ажиллагааны орлого 267.9 сая төгрөгөөр тус тус тасарчээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 46,474.7 сая төгрөг гарч 93.3 хувийн биелэлттэй, 3,344.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөв нийт 3,344.2 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан нь цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал 2,785.3 сая, хөрөнгө оруулалтыг гүйцэтгэлээр санхүүжүүлснээс 438.2 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 5,160.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,722.2 сая төгрөгийн санхүүжилт олгосноос Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн барилгын хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 1,085.0 сая төгрөгийг Сангийн яамны барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгөөс 763.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 576.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.9 сая, нийт 1,341.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,118.5 сая, хөрөнгийн зардалд 4.8 сая, нийт 1,123.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 217.9 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Татварын албадын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 4983 мэдээлэл байршуулахаас 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй байна. Тухайлбал: төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингаас бусад орлого, зарлагын гүйлгээ зэрэг болно.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 96.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 276.5 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт.3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	96.3	1	96.3			100.0
Зөвлөмж	4	276.5	4	269.5			90.0
Нийт	5	372.8	5	365.8			95.0

/сая төгрөг/

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 29 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдаж, Булган, Дорноговь аймгийн татварын хэлтсүүдэд итгэл үзүүлсэн тул аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 29 дүгнэлт өгч, аудитаар нийт 1,800.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,025.8 сая төгрөгийн 45 алдааг аудитын явцад залруулж, 5.6 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 95.8 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 169.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 50 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд хөрөнгө капиталжуулаагүй 165.1 сая, үндсэн хөрөнгө орлогод аваагүй 223.3 сая төгрөгийг тус тус дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 1,085.0 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого болон хөрөнгийн шилжүүлгийг илүү, 388.4 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 21.1 сая төгрөгөөр хасах үлдэгдэлтэй нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 2.6 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг дутуу, урсгал зардлыг илүү, 0.7 сая төгрөгөөр урсгал зардал болон үйл ажиллагааны мөнгөн орлогыг илүү нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалингийн зардлыг 1.0 сая төгрөгөөр бууруулж бүртгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас хийлгэх гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Татварын албадын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 4983 мэдээлэл байршуулахаас 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр мэдээлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Төвлөрүүлсэн захирагчид 382.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалт, сугалааны хонжворын урамшууллын нийт санхүүжилт 283,552.6 сая төгрөг бөгөөд хувь хүний нууцтай холбоотой асуудал тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу тулган баталгаажуулах, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан. Иймд дараагийн тайлант хугацаанд тусгайлсан шалгалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Татварын албадын хэмжээнд 59 автомашин бүртгэлтэй ба үүнээс 2500 см³ дээш хөдөлгүүрийн багтаамжтай 24 автомашин байна. Мөн албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй 35 албан тушаалтан автомашин ашиглаж байгаа асуудлыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд урсгал зардлын төсвөөс 294.0 сая төгрөгийн хөрөнгө /автомашин/ худалдан авч бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2 Эрсдэл:

Хууль хэрэгжихгүй байх, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах;

1.3 Өгсөн зөвлөмж:

Урсгал зардлын төсвөөс хөрөнгө бэлтгэхгүй байх, холбогдох хууль, тогтоомж, журам зааврыг мөрдөж ажиллах;

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

ТЕГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого 4.9 хувь буюу 184.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 99.9 хувь буюу 267.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Мөн Татварын албадын хэмжээнд 49.7 сая төгрөгийн 166,560 ширхэг ашиглах боломжгүй үнэт цаас бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, ТБОНӨТХ-ийн 31 дүгээр зүйл “Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах”, 31.1.1-д “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2 Эрсдэл:

Төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөө биелэхгүй байх, төсвийг үндэслэлгүй төлөвлөх;

2.3 Өгсөн зөвлөмж:

1. Шинэчилсэн татварын хуультай уялдуулан байгууллагын орлогын төлөвлөгөөг үнэн зөв, бодитой тооцоололд үндэслэн тооцож, төсвийн төсөлд санал өгч батлуулах;

2. Ашиглах боломжгүй үнэт цаасыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, хяналтад устгах;

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн ирүүлээгүй, зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлбар тодруулгагүй бэлтгэсэн, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-д “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт; Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-д “Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана”, 2.3-т “Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг ТГТ-1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтын дагуу боловсруулаагүй байх, хөтөлбөр арга хэмжээг үнэлэх боломжгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж:

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж хэвших;

2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалуудаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэж жилийн санхүүгийн тайлантай хамт хүргүүлж байх;

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Шинэчлэгдсэн татварын хуулиудын талаарх сурталчилгаа нэвтрүүлэг, шторк түгээх ажил үйлчилгээний гэрээт ажлын зарцуулалтаас гэрээ дүгнэсэн актгүй 52.3 сая, үр ашиггүй 36.0 сая төгрөгийн зардал тус тус гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.4.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах;

4.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажлын гүйцэтгэлийн холбогдох нотлох баримтын бүрдлийг хангаж бүртгэл тайланд тусгах, үр ашиггүй зардал гаргахгүй, зөрчлийг дахин давтахгүй байх;

4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/1/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Татварын ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас хийлгэх гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	146.1	Төлбөрийн акт	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн
2	Татварын албадын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 4983 мэдээлэл байршуулахаас 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.		Албан шаардлага	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн
3	Тайлант онд урсгал зардлын төсвөөс 294.0 сая төгрөгийн хөрөнгө /автомашин/ худалдан авч бэлтгэсэн байна.	294.0	Зөвлөмж өгөх	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн
4	ТЕГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого 4.9 хувь буюу 184.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 99.9 хувь буюу 267.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Мөн Татварын албадын хэмжээнд 49.7 сая төгрөгийн 166,560 ширхэг ашиглах боломжгүй үнэт цаас бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна.		Зөвлөмж өгөх	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн
5	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн ирүүлээгүй, зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлбар тодруулгагүй бэлтгэсэн, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаагүй байна.		Зөвлөмж өгөх	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн

6	Шинэчлэгдсэн татварын хуулиудын талаарх сурталчилгаа нэвтрүүлэг, шторк түгээх ажил үйлчилгээний гэрээт ажлын зарцуулалтаас гэрээ дүгнэсэн актгүй 52.3 сая, үр ашиггүй 36.0 сая төгрөгийн зардал тус тус гаргасан байна.	88.3	Зөвлөмж өгөх	ТЕГ-ын дарга Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Б.Бямбасүрэн
	ДҮН	528.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 дугаар сарын 25

№ 98/А0160061

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас хийлгэх гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлээгүй, гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146,093,613.25 / нэг зуун дөчин зургаан сая ерэн гурван мянга зургаан зуун арван гурван төгрөг хорин таван мөнгө/-ийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

П.ЧАНЦАЛДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 418/АД160061

Улаанбаатар хот

С.АГ- 2021/1/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Татварын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын албадын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 4983 мэдээлэл байршуулахаас 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр мэдээлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

П.ЧАНЦАЛДУЛАМ

[illegible]